

ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ
МОНГОЛЫН УУЛ
УУРХАЙН КОМПАНИ



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ: ХАМТЫН АЖИЛЛАГАА





ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ТАЛБАВД АРХЕОЛОГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖИЙН ЖАГСААЛТ

№	Судалгааны газар	Боловсролгүй	Он	Аймаг	Судалгааны өдөр
1	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2001	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
2	Өвөрхангай аймаг, Цогцолын сумын талбайд	2. Дамуусуур	2002	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
3	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2002	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
4	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
5	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
6	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
7	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
8	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
9	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
10	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
11	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
12	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
13	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
14	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
15	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
16	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
17	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
18	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
19	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр
20	Өвөрхангай аймаг, Ховд сумын ууган гурван дэвсгэрийн талбайд	2. Дамуусуур	2003	Ховд	Уулзны сумын ууган олон язгууртны байр



ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН БОДЛОГО

Оюу Толгой ХХК-ийн үндсэн бодлого нь харилцан итгэлцэл, ашиг сонирхол, ил тод байдал, хамтын эрмэлзэлд суурилсан тогтвортой харилцааг орон нутгийн иргэд, засаг захиргаа болон иргэний нийгмийнхэнтэй үүсгэхэд оршино.

Энэхүү харилцааг бий болгож, бэхжүүлэхэд уурхайн нөлөөллийн бүсийн иргэдтэй хэлэлцүүлэг, үүлзалт зохион байгуулах зэргээр хамтын

ажиллагааны олон арга барилыг ашиглаж байна.

Хэлэлцүүлэг нь орон нутгийн иргэдтэй байнгын харилцаатай байх, тэднийг төслийн бүтээн байгуулалтын талаар мэдээллээр хангах, хамтран ажиллах, үүсч болзошгүй нөлөөллийг олж илрүүлэх, мөн нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөх зэрэг олон зорилготой болно. ■

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Энэхүү үнэлгээ нь Оюу Толгой төслөөс нутгийн иргэд, байгаль орчин, ажилчдад

үзүүлж болзошгүй Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаарх нэгдсэн судалгаа юм.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын стандартад нийцүүлэн хийдэг бөгөөд үр дүнг ч тодорхой шалгуурын дагуу авч үзэж ашигладаг.

Бид Оюу Толгой төслийн талаархи мэдээллээр иргэдийг байнга хангаж, эргэх холбоог батжуулан, хийж байгаа ажлаа хэрхэн сайжруулах талаарх тэдний саналыг сонсох бодлого баримталдаг.

Мөн орон нутгийн иргэд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах чиглэлээр Оюу Толгой ХХК-ийн цаашид гүйцэтгэх ажилд саналаа тусгах боломж олгох зорилгоор энэхүү үнэлгээг хийсэн юм.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь орон нутгийн ард иргэдийн сайн сайхны төлөө хийх ажлаа төлөвлөхдөө тэдний саналыг нэг бүрчлэн авч тусгах боломжийг бүрдүүлэх төдийгүй компанийн алсын хараа, эрхэм зорилго болон үнэт зүйлсдээ нийцэж байдгаараа чухал ач холбогдолтой юм.

Энэхүү үнэлгээг олон улсын болон дотоодын 50 гаруй зөвлөхүүд боловсруулсан юм. ■

БИД ЯМАР АЖИЛ ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ВЭ?

Оюу Толгой ХХК Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг үндэслэн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны 22 чиглэлийн төлөвлөгөөг боловсруулсан. Эдгээрээс

- **Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд,**
- **Тоосжилт,**
- **Ус,**
- **Ажлын байр,**
- **Соёлын өв** зэрэг чиглэлүүдийг танилцуулж байна.



ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨРӨНГӨ ОРУУЛНА

Орон нутгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр Оюу Толгой ХХК олон хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнд: БЗДХ, сүрьеэ, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх төслийг 187.000 ам.доллаараар санхүүжүүлж, Ханбогд суманд шүдний кабинет нээхийн зэрэгцээ эмнэлэгт түргэн тусламжийн 2 автомашин хандивлаж, Өмнөговь аймагт Эрүүл мэндийн газрын сургалтын төвийг тохижуулахад хөрөнгө оруулах зэрэг олон ажлыг гүйцэтгэж байна.



Өмнөговь аймагт хэрэгжүүлсэн эмчийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд алслагдсан сумдад ажиллаж байгаа эмч нарыг орон сууцаар хангах, цалингийн нэмэгдэл олгож ирсэн билээ. Сүүлийн гурван жилд давхардсан тоогоор 33 эмч нарт 133 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

ТООСЖИЛТЫГ БУУРУУЛЖ, ХЯНАНА

Тоосжилтыг бууруулах чиглэлээр Оюу Толгой ХХК хяналт шинжилгээний ажлыг тогтмол хийдэг. Мөн тоосжилтын түвшинд хяналт тавьж, цэвэрлэх байгууламжаар дамжин гарсан усаар замын тоосжилтыг дарах, уурхайн талбайд зорчиж байгаа аливаа техник хэрэгслийг зөвхөн тогтсон замаар, заасан хурдны хязгаараар явуулах, уурхайн талбайгаас БНХАУ-ын хил хүртэл засмал тавих зэрэг төслийг хэрэгжүүлж байна.



УСЫГ ДЭЭД ЗЭРГЭЭР АРВИЛАН ХЭМНЭНЭ

Усны чиглэлээр Оюу Толгой ХХК орон нутгийн иргэдийн ашиглаж буй усны нөөцөд хяналт шинжилгээ хийх, малчдын хэрэгцээнд зориулан гар худаг гаргах, засаж сайжруулах, усны нөөц тогтоох зэрэг ажлыг гүйцэтгэж байна. Оюу Толгой уурхайд хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Ханбогд сумын нутаг болох Гүний хоолойд илрүүлсэн усны нөөцийн 20 хувийг ашиглах төдийгүй, хэрэглэсэн усныхаа 80 хувийг эргүүлж ашиглах юм. Үйлдвэрлэлийн явцад хамгийн үр ашигтай хаягдал өтгөрүүлэгч ашиглахаар мөн төлөвлөсөн. Үүнээс гадна үйлдвэрээс гарч байгаа хаягдал усыг бүрэн эргүүлэн татаж баяжуулах үйлдвэрт ашиглана.



Хөргөлтийн усыг 100 хувь, уурхайн гүний усыг 100 хувь, ахуйн бохир усыг 100 хувь, автомашин угаалгын усыг 100 хувь тус бүр цэвэрлэж дахин ашиглана. Мөн Ханбогд, Даланзадгад сумын иргэдийн хэрэглээний усны нөөцийг илрүүлэх судалгааны ажлыг гүйцэтгэж нийт 1.7 тэрбум төгрөг зарцуулаад байна. Өнгөрсөн хугацаанд малчдын 20 гар хүдгийг шинээр гаргаж, засаж сайжруулсан.

АЖЛЫН БАЙРНЫ БОЛОМЖ ОЛГОНО

Орон нутгийн иргэдийг ажилд авах, мэргэшүүлж, сургах талаар Оюу Толгой ХХК олон ажлууд хийж гүйцэтгэж байна. Оюу Толгой ХХК нь ажилтан сонгон шалгаруулахдаа нутгийн иргэдэд илүү боломж олгодог.

Өмнөговь аймгаас нийт 1727 хүн (2012 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар) Оюу Толгой төсөлд ажиллаж байна.

Оюу Толгой ХХК Ханбогд суманд 3.6 орчим тэрбум төгрөгөөр Техникийн сургалтын төвийг барьж ашиглалтад оруулсан. Энэ төв дээр Оюу Толгой ХХК болон орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилчид бэлтгэх, англи хэл, компьютер, менежмент зэрэг чиглэлээр сургалтууд зохион байгуулж, механикч, гагнуурчин, цахилгаанчин зэрэг мэргэжлээр 20-24 долоо хоногийн дадлага хийх боломжтой юм.

СОЁЛЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ, ХАМГААЛНА

Соёлын өвийн чиглэлээр Оюу Толгой ХХК орон нутгийн соёлын өвийг хадгалж, хамгаалах, цаашид хөгжүүлэх чиглэлээр төслийн талбайд археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаа хийх, соёлын өвийн олдоцыг авран хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэж байна. Мөн 2011

онд Өмнөговь аймгийн соёлын өвийн иж бүрэн бүртгэлийг хийх, хамгаалан хөгжүүлэх цогц хөтөлбөрийг Монголын болон дэлхийн тэргүүний эрдэмтэн судлаачидтай хамтран боловсруулсан бөгөөд энэ ажилд нийтдээ 2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгээд байна. Энэ ажил нь Монголын бусад уул уурхайн компаниудад соёлын өвийн талаар төрийн байгууллагуудтай хэрхэн ажиллах жишгийг тогтоосон бөгөөд судалгааны үр дүнд гарсан зөвлөмжийг Өмнөговь аймгийн удирдлагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Соёлын өвийн хөтөлбөрөөр дамжуулан соёлын өвийг доройтлоос сэргийлэх, соёлын өөрчлөлтийг судлах, ойлгох, соёлын өвийг хайрлан хамгаалах явдлыг дэмжихэд чиглэсэн алхамуудыг хэрэгжүүлж байна. ■



ОРОН НУТГИЙН ИРГЭДТЭЙ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ХАРИЛЦАА БИЙ БОЛГОЛОО

Оюу Толгой ХХК орон нутгийн иргэдтэй ил тод, нээлттэй харилцаж санал бодлоо чөлөөтэй солилцож ирсэн. Тухайлбал, Оюу Толгой төслийн талаар хувь хүн, бүлэг хүмүүс, байгууллага, аж ахуйн нэгжүүд санал, гомдол гаргасан бол төрлөөс нь хамааран асуудлыг 2 долоо хоногоос 1 сарын хугацаанд багтаан шийдвэрлэдэг.

Үүний зэрэгцээ орон нутгийн иргэдтэй ил тод, нээлттэй харилцах ажлынхаа хүрээнд орон нутгийн хэлэлцүүлэг, ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, нээлттэй хаалганы өдөрлөг, нийт иргэдийн уулзалт зэргийг зохион байгуулдаг. Орон нутгийн иргэдтэй хийх уулзалт сар бүр тодорхой сэдвээр явагдаж, тогтмолжлоо. ■

САНАЛ ГОМДОЛ БАРАГДУУЛАХ ДАРААЛАЛ

АЛХАМ 1	АЛХАМ 2	АЛХАМ 3
Иргэн та гомдлын маягыг Оюу Толгой ХХК-ийн оффисоос авч бөглөөд Оюу Толгой ХХК-ийн ажилтнуудад өгнө. Ажилтан нь маягыг хянаж, дотоод удирдлагын системд бүртгэнэ.	Оюу Толгой ХХК-ийн ажилтнууд нь анхан шатны үнэлгээ яаралтай тусламж шаардлагатай эсэхийг нягтлана. Хэрэв шаардлагатай бол эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин аюулгүй байдлын хэлтэст мэдээлдэг.	Гомдол гаргасан хүнд анхан шатны мэдээлэл эргэн хүргэнэ. Хэрэв ийм шаардлагагүй бол эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин аюулгүй байдлын хэлтэст мэдээлнэ.
АЛХАМ 4	АЛХАМ 5	АЛХАМ 6
Иргэн таны гомдлын мөрөөр мэдээлэл цуглуулах, шийдвэрлэх ажил хийгдэнэ. Үүний тулд судалж үзэх багийг томилох, холбогдох арга хэмжээ авах, шаардлагатай үед гуравдагч этгээдэд хандах, гомдлыг шийдвэрлэсэн тухай хариуг бичгээр хүргүүлэх зэрэг арга хэмжээ авна.	Иргэдийн ирүүлсэн гомдлыг хаана. Хэрэв гомдлын талаархи шийдвэр хангалтгүй гэж үзвэл алхам 4-ийг дахин хэрэгжүүлнэ.	Гомдол гаргасан хүн хангалттай гэж үзвэл хаах, эс тэгвэл дараагийн шатны арга хэмжээ авна. Мөн ОНХТХХ-ийн дотоод системд бүртгэх, ОНХТХХ-ийн Захиргааны ажилтнууд компанийн архивт шилжүүлэх зэрэг ажлууд хийгдэнэ.

ИЛ ТОД - НЭЭЛТТЭЙ - ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОЛ

Орон нутгийн хэлэлцүүлэг	Ганцаарчилсан болон бүлгийн уулзалт	Нээлттэй хаалганы өдөрлөг	Иргэдийн сар бүрийн уулзалт
Орон нутгийн хэлэлцүүлгийг олон арга барилаар зохион байгуулдаг. Эдгээр арга хэлбэр бүр тодорхой цаг хугацааны давтамж, төлөвлөгөөний дагуу явагддаг.	Ганцаарчилсан уулзалтыг иргэдийн хүсэлтийн дагуу байнга хийдэг. Харин бүлгийн уулзалтыг улирал бүр тогтмол хийж ирлээ.	Хэлэлцүүлэг болон тодруулга хийх олон арга барилын нэг нь нээлттэй хаалганы өдөрлөг юм. Энэхүү өдөрлөгийг жил бүр зохион байгуулж байна.	Иргэдтэй хийх уулзалтыг сар бүр тодорхой сэдвээр явуулдаг. Өнгөрсөн хугацаанд ус, ханган нийлүүлэлт, ажлын байр, соёлын өв зэрэг сэдвүүдээр явагджээ.

ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦАЖ САНАЛАА ӨГНӨ ҮҮ

*Иргэд та бүхэн Байгаль орчин,
нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй
танилцаж, хийж гүйцэтгэх ажилд
өөрийн саналаа өгнө үү.*



Үнэлгээтэй хаанаас танилцаж болох вэ?

Та бүхэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй WWW.OT.MN вэб сайт болон Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд дахь Оюу Толгой ХХК-ийн оффис, Ханбогд сумын Ёслолын өргөө, Манлай сумын Мэдээллийн танхим, ЗДТГ, Баян-Овоо сумын дунд сургууль, Даланзадгад сумын Төв номын сан болон Иргэний танхим, Улаанбаатар хотын Оюу Толгойн мэдээллийн төв зэрэг газруудаас танилцах боломжтой.

Саналаа хаана өгөх вэ?

Иргэд та бүхэн саналаа бичгээр өгөх бол саналын маягт бөглөн дээрхи газруудад байрласан саналын хайрцагт хийнэ. Мөн OTESIA@ot.mn хаягаар цахим шуудангаар илгээх боломжтой. Хэрэв та БОННУ-ний тухай асуулт бүхий цахим шуудан хүлээж авбал OTESIA@ot.mn хаягаар илгээнэ. Үүнээс гадна Оюу Толгой ХХК-ийн ажилтнуудтай уулзаж саналаа амаар гаргаж болно. ■

Санал авах үйл ажиллагаа 2012 оны 8 дугаар сарын 6-наас 60 хоногийн хугацаатай үргэлжилнэ.





МЭДЭЭЛЭЛ АВАХ ГАЗАР

Оюу Толгой ХХК

Улаанбаатар – 14240

Сүхбаатар дүүрэг

Чингисийн өргөн чөлөө – 15

“Моннис” цамхаг

Утас: 976-11-331880

Факс: 976-11-331890

Веб сайт: www.ot.mn

Мэдээллийн төв

Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага Тойруугийн гудамж,
Одқон Холдинг байр, 1-р давхар (МУИС 4-р байр, Эдийн
засгийн сургуулийн баруун талд)

Утас: 976-11-353366

Э-шуудан: infocenter@ot.mn

Ханбогд сум дахь салбар оффис

Монгол улс, Өмнөговь аймаг

Ханбогд сум, Цаг уурын гудамж 1, Хаалга 5

Утас: + (976) 01535 12188, + (976) 01535 12194

Баян-Овоо сум дахь салбар оффис

Монгол улс, Өмнөговь аймаг

Баян Овоо сумын Засаг даргын Тамгын газрын байр

Утас: + (976) 99058766, + (976) 96963338

Манлай сум дахь салбар оффис

Монгол улс, Өмнөговь аймаг

Манлай сум, Засаг даргын Тамгын газрын байрны өргөтгөл

Утас: + (976) 88164155, + (976) 96963337

Даланзадгад дахь төлөөлөгчийн газар

Монгол улс, Өмнөговь аймаг

Даланзадгад сумын 3-р баг, Тост Говь ХХК-ийн байр

Утас: + (976) 7053 3941

Факс: + (976) 7053 3963

Шуудангийн хаяг: Өмнөговь аймгийн Даланзадгад сумын
шуудангийн газар, ШХ-463